- Авлага дансны үлдэгдэл 826,108.4 мянган төгрөгөөр буюу 7.9 дахин өссөн нь улсын төсвийн орлого бүрдүүлэлтээс хамааран Сангийн яамнаас нэгдсэн бодлогоор урсгал төсөв болон нэмэлт санхүүжилтийн эрхийг нээж өгөөгүйгээс Төрийн сангаар гүйлгээ хийгдэх боломжгүй хязгаарлагдаж, дансны үлдэгдлийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна. Авлагын үлдэгдэлд нэмэлт санхүүжилтээс татан төвлөрүүлсэн 418,802.4 мянган төгрөг, Сангийн сайдын 2025 оны А/240 тушаалаар “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны орлогыг зарцуулах, тайлагнах журам” шинэчлэгдсэнтэй холбоотой давсан орлогын 409,496.2 мянган төгрөгийн татаас, санхүүжилтийн авлага байна. Олон жил болсон авлагын үлдэгдлийг шүүх хяналтын байгууллагад шилжүүлж, шүүхийн шийдвэрийг үндэслэн 2,596.0 мянган төгрөгийн авлагыг данснаас хассан байна.
- Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 141,570.4 мянган төгрөгөөр буюу 2.7 дахин өсжээ. Тайлант онд бараа материал худалдан авсан 413,478.3 мянган төгрөг, хандив тусламж хөрөнгө оруулалтаар 35,761.0 мянган төгрөг, нийт 449,239.3 мянга төгрөгөөр тус тус нэмэгдэж, зарцуулсан 292,945.9 мянган төгрөг, тус төвийн даргын 2025 оны А/148 дугаар тушаалаар акталж устгасан 14,722.9 мянган төгрөг, нийт 307,668.9 мянга төгрөгөөр хасагдсан байна.
- Үндсэн хөрөнгө үлдэгдэл 2,930,479.8 мянган төгрөгөөр буюу 2.3 дахин өссөн байна. Тайлант онд худалдан авалтаар 3,294,398.1 мянган төгрөгийн, яамны хөрөнгө оруулалтаар 3,210,177.1 мянган төгрөгийн, 2018 онд ГБХНХЯ-аас балансаас шилжиж ирсэн 55,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий ТЕАНА авто тээврийн хэрэгслийг данс бүртгэлд тусгасан дүнгээр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2025 оны 569 дүгээр тогтоолоор 220,512.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, тооллогоор дутагдсан 6,828.4 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасаж авлага үүсгэсэн дүнгээр хасагдсан байна.
- Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 542,658.8 мянган төгрөгөөр буюу 92.8 хувиар өссөн нь 2025 оны 9 дүгээр сараас хойш байгууллагын хэвийн үйл

ажиллагааг хангах урсгал зардлын өр хуримтлагдсан, нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан НДЕГ-аас ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудын зохион байгуулсан арга хэмжээ, ажлын гүйцэтгэлийн 418,802.4 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,894,444.9 мянган төгрөг болж, 3,355,499.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Программ хангамжийн талаарх судалгаа авахад тус байгууллага нь 2023 онд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн 3,822.5 мянган төгрөгийн өртөгтэй нягтлан бодох бүртгэлийн “Fiscus” программ хангамжийг ашиглаж байгаа бөгөөд тайлант онд 1,650.0 мянган төгрөгийн лицензийн төлбөр төлсөн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төв нь 2025 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 8,344,164.5 мянган төгрөг, ЭМДС-аас 108,000.0 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,204,966.6 мянган төгрөг бүрдүүлж, нийт 9,657,131.1 мянган төгрөгийн нийт зарлагыг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 1,088,694.8 мянган төгрөгөөр бууруулж, 8,568,436.3 мянган төгрөгөөр баталсан байна. Тухайлбал: цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 742,397.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 15,218.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 147,538.6 мянган төгрөг, нормативт зардлыг 86,196.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 16,103.8 мянган төгрөгөөр тус тус бууруулсан нь төсвийн төслийг тооцоо судалгаагүй, үндэслэлгүй боловсруулсан байна.

Тайлант оны 7 дугаар сард батлагдсан төсвийг 651,488.6 мянган төгрөгөөр бууруулж, 7,916,947.7 мянган төгрөгөөр тодотгосон ба 12 дугаар сард дахин 458,931.1 мянган төгрөгөөр бууруулж, 7,458,016.6 мянган төгрөгөөр баталжээ.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,794,128.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 108,000.0 мянган төгрөгийг ЭМДС-аас, 1,555,888.6 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвийн санхүүжилтээр 2,923,390.4 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоор 1,965,384.9 мянган төгрөг, нийт 4,888,775.3 мянган төгрөгийн орлого орж нийт 4,479,279.1 мянган төгрөгийг зарцуулж 60.1 хувийн биелэлттэй

байна. Үндсэн үйл ажиллагааны орлого 409,496.3 мянган төгрөгөөр давж биелэн төсөвт төвлөрүүлж авлагаар бүртгэсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

		/мянган төгрөгөөр/			
Хөтөлбөр, арга хэмжээний нэр		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
72103	Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй	7,458,016.6	4,888,775.3	2,569,241.3	65.6
80101	Үндсэн үйл ажиллагаа	7,258,414.1	4,691,665.1	2,566,749.0	64.6
80802	Нэг удаа олгох тэтгэвэр тэтгэмж, урамшуулал	163,724.1	161,231.8	2,492.3	98.5
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	35,878.4	35,878.4	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

- Тайлант онд тус байгууллагын орон тоог 179-оор баталж, 6,303,660.2 мянган төгрөгийн цалингийн зардлыг төлөвлөсөн ба тодотголоор 16-аар буюу 9 хувиар бууруулж 163 болгон 5,889,080.5 мянган төгрөгийн цалингийн зардалд баталсан байна. Гүйцэтгэлээр удирдах 1, гүйцэтгэх 105, үйлчилгээний 12 нийт 118 албан хаагчтайгаар 3,431,780.0 мянган төгрөгийн цалингийн зардалд гарсан байна. Орон тоо дутуу байгаа нь тус ЭМТ-ийн барилга 2025 оны 12 дугаар сард ашиглалтад орж хэрэгцээтэй орон тоог ажиллуулах нөхцөл бүрэн бий болоогүйтэй холбоотой байна.
- Тус төвийн даргын 2025 оны Б/06 дугаар тушаалаар албан хаагчдад ажлын нэг өдрийн хоолны зардалд 23.0 мянга, унааны зардалд 2.0 мянган төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн байна. Тайлант онд нийт 500,702.3 мянган төгрөгийг хоолны хөнгөлөлт, 38,001.9 мянган төгрөгийг унааны хөнгөлөлт, нийт 538,704.2 мянган төгрөгийг олгожээ.
- НДҮЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 06 дугаар тогтоол, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн А/75 тушаалаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор ХАБЭМ-ийн үндэсний чуулганыг 179,915.6 мянган төгрөгийн төсөвтэй зохион байгуулсан байна. Тус арга хэмжээний зардлыг НДЕГ-ын ҮОМШӨ-ний даатгалын сангаас санхүүжүүлсэн байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журмын хэрэгжилтийг хангах гэрээний үндсэн дээр НДЕГ-аас 854,477.1 мянган төгрөгийн, НҮБ-ын ОУ-ын хөдөлмөрийн байгууллагаас “Жижиг дунд үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг дэмжих” сургалт, судалгаа хийх ажлыг зохион байгуулах 46,795.8 мянган төгрөг, нийт 901,272.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 6,379.5 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардалд 6,000.0 мянган төгрөг, хангамж материалын зардалд 133,401.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 11,900.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 308,589.4 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 200.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 16,000.0 мянган төгрөгийн зарцуулж, 418,802.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

#### **1. Урсгал төсвийн хүрээнд:**

Тайлант онд нээлттэй тендер сонгон шалгаруулалтын журмаар 642,600.0 мянган төгрөг, онцгой журам ба шууд худалдан авах аргаар 129,107.1 мянган төгрөг, нийт 771,707.1 мянган төгрөгийн худалдан авалт хийхээр худалдан авах ажиллагааны төлөвлөө батлагдсан байна. Тайлант оны 7 дугаар сард төсөвт тодотгол хийгдэж 25,051.0 мянган төгрөгөөр бууруулан, 746,656.1 мянган төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр онцгой журам ба шууд худалдан авалтын аргаар 51,365.3 мянган төгрөг, нээлттэй тендер сонгон шалгаруулалтаар 534,262.4 мянган төгрөг нийт 585,627.7 мянган төгрөгийн худалдан авалт хийж, гүйцэтгэл 78.4 хувьтай байна.

Батлагдсан төлөвлөгөөнөөс онцгой журам ба харьцуулалтын аргаар худалдан авах 35,801.0 мянган төгрөгийн нормын хувцас зөөлөн эдлэл, 30,858.0 мянган төгрөгийн хөдөлмөр хамгааллын хэрэгслэл нийт 66,659.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг тус тус зарлаж, амжилттай хэрэгжсэн боловч Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар гарсантай холбоотой гүйцэтгэл гараагүй байна.

#### **2. НДҮЗ-ийн ҮОМШӨ-ний даатгалын сангийн хүрээнд:**

НДҮЗ-ийн 2025 оны 06 дугаар тогтоолоор баталсан ҮОМШӨ-ний даатгалын сангаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шууд худалдан авалтын аргаар 253,000.0 мянган төгрөг, нээлттэй тендер сонгон шалгаруулалтын журмаар 1,083,000.0 мянган төгрөгийн нийт 1,336,000.0 мянган төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр шууд худалдан авалтын аргаар 16 удаагийн 231,743.5 мянган төгрөг, нээлттэй тендер сонгон шалгаруулалтын журмаар 9 удаагийн 1,032,728.0 мянган төгрөг нийт 1,264,471.5 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Тус төвийн үйл ажиллагааг сайжруулах, төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох хуулийн дагуу гаргаж тайлагнах, үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй, бодитой төлөвлөхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Платиниум прогресс аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор Н.Номин-Эрдэнэ, Э.Туяасайхан нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг захирал Ж.Баяртуул, үе шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Өсөхжаргал, аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/41 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт зардал 4,587,332.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 45,873.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тайлант онд тус төвийн нийт зардал тогтолцооны шинэчлэлтэй холбоотойгоор өмнөх оноос 3,970,189.6 мянган төгрөгөөр буюу 1.9 дахин өсөж 8,557,522.0 мянган төгрөг болсон тул гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг шинэчлэн 85,575.2 мянган төгрөгөөр тогтоов.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор, үр ашиггүй зардал гаргалгүй ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн судалгаагаар орон нутагт томилолтоор ажиллахдаа хувийн хэвшлийн болон төрийн өмчийн аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгслээр үйлчлүүлээгүй, тэтгэвэрт гарахад олгосон нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг бусад тэтгэмжтэй давхардуулан олгоогүй байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан. Нийцлийн асуудлаар илэрсэн бусад хууль тогтоомжийн хүрээнд 1 зөвлөмж өглөө.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант оны шилэн дансны цахим хуудсыг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 169, хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байна.

Шилэн дансанд мэдээлсэн цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 4,274,149.5 мянган төгрөгийн орлогын 100 гүйлгээ, 1,312,091.9 мянган төгрөгийн зарлагын 73 гүйлгээг тулган шалгахад тохирч байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв нь дэргэд ахмадын хороогүй, Ахмадын тухай хуульд заасны дагуу ахмадын мөнгөн санг төсөвтөө төлөвлөж батлуулаагүй байна.

Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7. “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална”, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын “1.2.Байгууллага нь Ахмад настны тухай хуулийн 14.7-д заасан мөнгөн хөрөнгөөр ахмадын сан байгуулна. 1.3.Ахмадын сангийн хөрөнгө нь тухайн байгууллагын төсвийн нэг бүрэлдэхүүн хэсэг байна.” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ахмадын тухай хууль, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-д заасны дагуу эх үүсвэрийг бүрдүүлж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өглөө.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй бөгөөд тухайн хугацаанд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, гадаад, дотоод орчин, хяналтын талаар ойлголт олж, аудитын урьдчилсан судалгааны болон төлөвлөлтийн үе шатны ажлуудыг гүйцэтгэсэн.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 467,888.1 мянган төгрөгийн илэрсэн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, орлогын төлөвлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайлагналтай холбоотой асуудлуудад 2 зөвлөмж өгснөөс 3 албан албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, авлага барагдуулахтай холбоотой 1 албан шаардлага 26.2 хувьтай, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай, аудитын шийдвэрийн хэрэгжилт дунджаар 94.5 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	467,888.1	4	416,723.8	89.1
Зөвлөмж	2	-	2	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>467,888.1</b>	<b>6</b>	<b>416,723.8</b>	<b>94.5</b>

Өмнөх оны аудитаар 65,265.9 мянган төгрөгийн авлагад тооцоо нийлж баталгаажуулах албан шаардлага хүргүүлснээс 350.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, 2,641.3 мянган төгрөгийн авлагад тооцоо нийлж, хууль хяналтын байгууллагад 14,110.1 мянган төгрөгийн авлагыг шилжүүлснээс 2,596.0 мянган төгрөгийн авлага хүчингүй болж, 11,514.1 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага шийдвэрлэх шатандаа, 48,164.3 мянган төгрөгийн 4 байгууллагаас авлагын эзэн холбогдогч нь тодорхойгүй, хэрэгжилт 26.2 хувьтай байна.

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

- Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны “finperform.mof.gov.mn” цахим хуудасны байршуулсан маягт хоорондын зөрүүг арилгах;
- Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг “finperform.mof.gov.mn” цахим хуудасны байршуулсан жагсаалттай уялдуулах;

2. Ашиглалтад шинээр орсон барилга, ашиглагдаагүй хуучин оффисын барилга болон сувиллын байгууламжийн талаар эрх бүхий байгууллагад хандаж шийдвэр гаргуулсан эсэхэд анхаарч үзэх нь зүйтэй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,000.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

### Залруулсан алдаа:

- Тайлант оны аудитын төлбөрт төлөх 5,000.0 мянган төгрөгийн өглөгийг данс бүртгэлд тусгаж тайлагнаагүй;

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалттай нийцэхгүй, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 174,717.9 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 126,553.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 48,164.3 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 174,717.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 89,142.7 мянган төгрөгөөр их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар барилга, байгууламжтай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тайлант оны 12 дугаар сард тус төвийн оффисын барилга ашиглалтад орсон бөгөөд эрх бүхий байгууллагын шийдвэр нь гараагүй, данс бүртгэлд тусгаагүй;
2. Шинэ барилга ашиглалтад орохоос өмнө ашиглаж байсан 1,710,000.0 мянган төгрөгийн дансны үнэтэй барилга ашиглахгүй байгаа бөгөөд сард 1,378.2 мянган төгрөгийн ашиглалтын зардал төлж, төсвийг үрэлгэн зарцуулсан;
3. "Агаар сувилал"-ын 279,226.1 мянган төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламж нь сүүлийн жилүүдэд ашиглагдаагүй, чанар байдал нь муудаж, эвдрэл ихтэй болж цаашид ашиглахгүй боломжгүй болсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх Үнэн зөв байх, 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах," Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл. Төрийн байгууллага, албан газрын эд хөрөнгийн эрх..." 2. Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй: 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах; 2/ улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах;" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Шийдвэрлэсэн нь:** Шинээр ашиглалтад орсон барилгыг данс бүртгэлд тусгах, ашиглалтгүй байгаа эмнэлгийн болон сувиллын барилга байгууламжийг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх албан шаардлага хүргүүлэв.

2. Тус төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, албан хаагчдад төвийн даргын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/146 дугаар тушаалаар нийт 125,175.5 мянган төгрөгийн урамшуулал олгож, төсвийг үрэлгэн зарцуулжээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах,” Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 5 дугаар албан даалгаврын 1.4-т “тэвчиж болох дараах арга хэмжээ, зардлын санхүүжилтийг 2025 он дуустал хугацаанд зогсоож, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг хэмнэлттэй, үр ашигтай байдлаар зохион байгуулах:”, 1.4.2-т “байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр зогсоох” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан төсвийг хэмнэлттэй хуваарилж, зарцуулах, төсвийн сахилга батыг чангатгах, төрийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдаас даалгасан албан даалгаврыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Авлагатай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Он удаан жил болсон (2009-2018 онд үүссэн) эзэн холбогдогч нь тодорхойгүй 4 хуулийн этгээдтэй холбоотой нийт 48,164.3 мянган төгрөгийн авлагыг үлдэгдэлтэй гарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэснийг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг бүрэн хангаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Он удаан жил болсон эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Тайлант оны аудитын төлбөр 5,000.0 мянган төгрөгийг өр төлбөрөөр тайлагнаагүй.	1	5,000.0	1	5,000.0			1	5,000.0				
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>5,000.0</b>	<b>1</b>	<b>5,000.0</b>	-	-	<b>1</b>	<b>5,000.0</b>	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Он удаан жил болсон, эзэн холбогдогч нь тодорхойгүй 4 хуулийн этгээдтэй холбоотой нийт 48,164.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй.	1	48,164.3					1	48,164.3				
2	Тайлант оны 12 дугаар сард тус төвийн оффисын барилга ашиглалтад	1	-			1	-						

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	орсон бөгөөд эрх бүхий байгууллагын шийдвэр нь гараагүй, данс бүртгэлд тусгаагүй;											
	Шинэ барилга ашиглалтад орохоос өмнө ашиглаж байсан 1,710,000.0 мянган төгрөгийн дансны үнэтэй барилга ашиглахгүй байгаа бөгөөд сард 1,378.2 мянган төгрөгийн ашиглалтын зардал төлж, төсвийг үрэлгэн зарцуулсан.		1,378.1				1,378.1					
	“Агаар сувилал”-ын 279,226.1 мянган төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламж нь сүүлийн жилүүдэд ашиглагдаагүй, чанар байдал нь муудаж, эвдрэл ихтэй болж цаашид ашиглахгүй боломжгүй болсон.		-				-					
3	Тус төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, албан хаагчдад төвийн даргын 2025 оны А/146 дугаар тушаалаар нийт 125,175.5 мянган төгрөгийн урамшуулал олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан.	1	125,175.5			1	125,175.5					
<b>Дүн</b>		<b>3</b>	<b>174,717.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>126,553.6</b>	<b>1</b>	<b>48,164.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>									
1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв нь Ахмадын тухай хууль, Засгийн газрын тогтоолоор баталсан журмын дагуу ахмадын мөнгөн санг төсөвтөө төлөвлөж батлуулдаггүй байна.	1						1	
<b>Дүн</b>		<b>1</b>						<b>1</b>	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 374/А0150163

Улаанбаатар хот

САГ-2026/265/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар барилга, байгууламжтай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тайлант оны 12 сард тус төвийн оффисын барилга ашиглалтад орсон бөгөөд эрх бүхий байгууллагын шийдвэр нь гараагүй, данс бүртгэлд тусгаагүй;
2. Шинэ барилга ашиглалтад орохоос өмнө оффисоор ашиглаж байсан 1,710,000,000.00 төгрөгийн дансны үнэтэй барилга ашиглалтгүй, сард 1,378,153.00 (Нэг сая гурван зуун далан найман мянга нэг зуун тавин гурван) төгрөгийн ашиглалтын зардалд төсвийг үрэлгэн зарцуулсан;
3. "Агаар сувилал"-ын 279,226,100.00 (Хоёр зуун далан есөн сая хоёр зуун хорин зургаан мянга нэг зуун) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламж нь сүүлийн жилүүдэд ашиглагдаагүй, чанар байдал нь муудаж, эвдрэл ихтэй болж цаашид ашиглахгүй боломжгүй болох эрсдэлтэй болсон байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах," Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл. "Төрийн байгууллага, албан газрын эд хөрөнгийн эрх..." 2. Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй. 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах; 2/ улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах," гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-65.Docx

1526180814

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1. Шинээр ашиглалтад орсон барилгыг данс бүртгэлд тусгаагүй, эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй, уг барилга ашиглалтад орохоос өмнө ашиглаж байсан барилга ашиглалтгүй, ашиглалт зардалд төсвийг үрэлгэн зарцуулсан, ашиглалтгүй байгаа сувиллын барилга байгууламжийг зориулалтын дагуу ашиглах талаар дээд шатны байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, өөрт олгогдсон эд хөрөнгийн талаарх үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дарга Д.Нарансүх, ерөнхий нягтлан бодогч Д.Оюун-Эрдэнэ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ПЛАТИНИУМ ПРОГРЕСС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР

Ж.БАЯРТУУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 375/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/265/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн дарга 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр А/146 дугаар тушаал гаргаж үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, сайн үнэлүүлсэнтэй холбогдуулан албан хаагчдад нийт 125,175,460.00 (Нэг зуун хорин таван сая нэг зуун далан таван мянга дөрвөн зуун жаран) төгрөгийн цалингийн урамшуулал олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах," Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" 5 дугаар албан даалгаврын 1.4-т "тэвчиж болох дараах арга хэмжээ, зардлын санхүүжилтийг 2025 он дуустал хугацаанд зогсоож, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг хэмнэлттэй, үр ашигтай байдлаар зохион байгуулах:", 1.4.2-т "байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр зогсоох" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Улирлын үр дүнгийн урамшуулал олгосноос гадна жилийн цалингийн урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, дээд газраас улс орны хэмжээнд гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дарга Д.Нарансүх, ерөнхий нягтлан бодогч Д.Оюун-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ПЛАТИНИУМ ПРОГРЕСС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБЯАР  
Ж.БАЯРТУУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z: Alban-Shaardlaga2026/0125 SAG-65 Docx

1526180812